

ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭР

Хэлэлцэн тохиролцогч Талууд,

Ур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц /цаашид “Конвенц” гэх/-ийн Талууд болохын хувьд:

Конвенцийн Талуудын Бага хурлын арван долдугаар хуралдааны 1/CP.17 шийдвэрээр баталсан Дурбаны платформыг өргөжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор,

Конвенцийн үндсэн зарчимд тулгуурлан, үүний дотор эрх тэгш байдлын үндсэн дээр улс орнуудын хүлээх нийтлэг боловч ялгавартай үүрэг хариуцлагад нийцүүлэн, үндэсний онцлог байдлыг харгалзан Конвенцийн зорилгыг баримтлан,

Ур амьсгалын өөрчлөлтөөс нэн даруй учирч болох аюулын эсрэг шинжлэх ухааны хамгийн шилдэг ололтод суурилж, үр дүнтэй, дэвшилтэт хариу арга хэмжээ авах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч,

Конвенцид дурдсанаар, хөгжиж буй орон, ялангуяа ур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаварт эмзэг өртөмтгий Талуудын тодорхой хэрэгцээ шаардлага, онцлог байдлыг мөн хүлээн зөвшөөрч,

Санхүүжилт хийх, технологи дамжуулах үйл ажиллагаатай холбогдуулан буурай хөгжилтэй орнуудын тодорхой хэрэгцээ шаардлага, онцлог байдлыг бүрэн харгалзан үзэж,

Талууд ур амьсгалын өөрчлөлтөд төдийгүй түүний эсрэг авах хариу арга хэмжээний үр дагаварт өртөж болохыг хүлээн зөвшөөрч,

Ур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн үйл ажиллагаа, хариу арга хэмжээ, тэдгээрийн үр дүн нь тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг арилгахад тэгш хүртээмжтэй оролцохуйц бодит харилцаанд онцгой анхаарал хандуулж,

Хүнсний аюулгүй байдлыг хангах, өлсгөлөнг зогсоох, ялангуяа ур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаварт эмзэг өртөмтгий хүнсний үйлдвэрлэлийн тогтолцоог хамгаалах эн тэргүүний зорилтыг хүлээн зөвшөөрч,



Үндэсний хэмжээнд тодорхойлсон хөгжлийн тэргүүн зорилттой уялдуулан зохистой болон чанартай ажлын байр бий болгох, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний нөхцөл, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж,

Талууд уур амьсгалын өөрчлөлт нь хүн төрөлхтний нийтээр сэтгэл зовних зүйл болоод байгааг ухамсарлаж, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ аваадаа хүний эрх, уугуул иргэдийн эрх, орон нутгийн иргэдийн эрх, шилжин суурьшигчдын эрх, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх болон нийгмийн эмзэг бүлгийн эрх, тэдгээрийн хөгжих, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, мөн түүнчлэн эмэгтэйчүүдийн эрх мэдлийг өргөжүүлэх, жендерийн эрх тэгш байдал болон залгамж үе хоорондын эрх тэгш байдлыг хангах зэрэг асуудлын хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хүндэтгэж, хөхиүлэн дэмжиж,

Конвенцид тодорхойлсон хүлэмжийн хий шингээгч болон хуимтлуурыг зохих ёсоор хамгаалах, сайжруулахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ аваадаа “уур амьсгалын асуудлаарх шударга ёс” гэсэн үзэл баримтлалын ач холбогдол, түүнчлэн зарим соёл иргэншилд Эх дэлхий гэж нэрлэгдэх бүх экосистемийн нэгдмэл байдлыг хангах, үүний дотор далай, биологийн олон янз байдлыг хамгаалахын чухлыг тэмдэглэж,

Энэхүү Хэлэлцээрээр шийдвэрлэх асуудлын хүрээнд бүх шатанд боловсрол олгох, сургалт, сурталчилгааны ажил явуулах, олон нийтийн оролцоог хангах, олон нийтийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах, хамтран ажиллахын чухлыг нотолж,

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд Засгийн газрын бүх түвшний байгууллагууд болон оролцогч Талууд өөрсдийн үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн оролцохын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

Тогтвортой амьдралын хэв маяг, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэл бүхий хөгжингүй орон болох Талууд нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийг хүлээн зөвшөөрч,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов.

1 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан тодорхойлолтыг хэрэглэнэ. Нэмэлт байдлаар:



- a. "Конвенц" гэдэгт 1992 оны 5 дугаар сарын 9-нд Нью-Йорк хотноо баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийг ойлгоно.
- b. "Талуудын Бага хурал" гэдэгт Конвенцид оролцогч Талуудын Бага хурлыг ойлгоно.
- c. "Тал" гэдэгт энэхүү Хэлэлцээрт оролцогч Талыг хэлнэ.

2 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээр нь тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг арилгах хүчин чармайлтын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс учирч болох аюулын эсрэг авч хэрэгжүүлэх дэлхий нийтийн хариу арга хэмжээг бэхжүүлэхэд чиглэсэн Конвенцийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд орших бөгөөд эдгээр нь:

а. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдлийг бууруулахад онцгой ач холбогдолтой болохыг ухамсарлаж, дэлхийн агаарын дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад 2°C -аас доош барих, агаарын температурын өсөлтийг 1.5°C -т хязгаарлах хүчин чармайлт гаргах;

б. Хүнсний үйлдвэрлэлд аюул учруулахгүйгээр уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаварт дасан зохицох чадварыг дээшлүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадварыг бэхжүүлэх, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх;

с. Хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөгжилд хүрэхэд чиглэсэн санхүүгийн урсгалыг тогтвортой болгох зэрэг болно.

2. Энэхүү Хэлэлцээр нь үндэсний онцлог нөхцөл, эрх тэгш байдал, нийтлэг боловч ялгавартай хариуцлага болон бодит боломжид нийцүүлэх зарчимд тулгуурлан хэрэгжинэ.

3 дугаар зүйл

Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх дэлхий нийтийн хариу үйлдэл болох үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг Талууд 2 дугаар зүйлд тодорхойлсон Хэлэлцээрийн зорилтод хүрэхийн тулд 4, 7, 9, 10, 11 болон 13 дугаар зүйлд заасан хүчин чармайлтыг хэрэгжүүлж, мэдээлнэ. Энэхүү Хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хөгжиж буй орон болох Талуудад дэмжлэг үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг ухамсарласны үндсэн дээр Талуудын хүчин чармайлтад мэдэгдэхүйц ахиц гарна.



4 дүгээр зүйл

1. 2 дугаар зүйлд заасан агаарын температурыг бууруулах урт хугацааны зорилтод хүрэхийн тулд, Талууд тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг арилгах асуудлын хүрээнд, эрх тэгш байдлын үндсэн дээр, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн зорилгод аль болох хурдан хүрэх, үүний тулд хөгжиж буй орон болох Талуудад илүү урт хугацаа шаардлагатайг ойлгож, шинжлэх ухааны ололтод үндэслэн ялгарлыг түргэн хугацаанд бууруулах арга хэмжээг авах, энэ зууны хоёрдугаар хагас гэхэд хүлэмжийн хийн эх үүсвэрүүдээс хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй ялгарах хэмжээ болон шингээгчид шингэж арилгах хэмжээ хоорондын тэнцвэрт байдлыг хангахыг тус тус зорино.
2. Талууд хүрэхээр зорьж байгаа үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн талаар бэлтгэх, тайлагнах болон хэрэгжүүлэх арга хэмжээ авна. Талууд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтуудыг хангах зорилгоор хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээг дотооддоо авч хэрэгжүүлнэ.
3. Талуудын үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр нь өмнө болон одоогийн тодорхойлсон хувь нэмрээс мэдэгдэхүйц илүү ахиц үзүүлэх ёстой бөгөөд үндэсний онцлог байдлыг харгалзан, хүрч болох хамгийн том зорилго болон Талуудын хүлээх нийтлэг боловч ялгавартай хүлээх үүрэг хариуцлага зэргийг тусгасан байна.
4. Хөгжингүй орон болох Талууд хүлэмжийн хийн ялгарлыг үнэмлэхүй хэмжээнд бууруулахад чиглэсэн эдийн засгийг бүрэн хамарсан зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Хөгжиж буй орон болох Талууд ялгарлыг бууруулах хүчин чармайлтаа цаашид үргэлжлүүлж, өөрийн орны үндэсний онцлогт тохирсон, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, түүнийг хязгаарлахад чиглэсэн эдийн засгийг бүрэн хамарсан зорилтод аажмаар шилжинэ.
5. Хөгжиж буй орон болох Талуудад үзүүлсэн дэмжлэгийн хүрээнд тэдгээрийн зорилго, үйл ажиллагаа нь өргөжих боломжтой болохыг хүлээн зэвшөөрч, хөгжиж буй орон болох Талуудад энэ зүйлд заасан арга хэмжээг 9, 10 болон 11 дүгээр зүйлд заасан арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
6. Буурай хөгжилтэй орнууд болон хөгжиж буй арлын жижиг улс өөрийн орны үндэсний онцлогийг тусгасан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн стратеги, төлөвлөгөө, арга хэмжээг бэлтгэж, мэдээлж болно.



7. Талуудын дасан зохицох үйл ажиллагаа болон/эсхүл эдийн засгийг төрөлжүүлэх төлөвлөгөөний үр дүнд бий болсон ялгарлыг бууруулах давхар үр өгөөж нь энэ зүйлд тодорхойлсон ялгарлыг бууруулах арга хэмжээнд хувь нэмэр оруулна.
8. Талууд 1/CP.21 шийдвэр болон Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаас гарсан аливаа шийдвэрийн дагуу үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн талаар мэдээлэхдээ ил тод, тодорхой, ойлгомжтой байх зарчмыг баримтална.
9. Талууд 1/CP.21 шийдвэр болон Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаас гарсан аливаа шийдвэрийн дагуу үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн талаар 5 жил тутамд мэдээлэх бөгөөд 14 дүгээр зүйлд заасан дэлхий нийтийн төлөв байдлын тухай мэдээллээр хангагдана.
10. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын анхны хуралдаанаар үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн нийтлэг хугацааны хүрээг хэлэлцэнэ.
11. Оролцогч Тал нь өөрийн орны үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтод хүрэх түвшинг ахиулах зорилгоор Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаар баталсан удирдамжийн дагуу хэдийд ч засвар оруулж болно.
12. Талуудын мэдээлсэн үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг Нарийн бичгийн дарга нарын газрын олон нийтийн бүртгэлд бүртгэнэ.
13. Талууд нь өөрийн үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг тооцоолно. Талууд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэрт тусгасан хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийг тооцоолоходоо Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаас батлан гаргасан удирдамжийн дагуу давхардуулан тооцоолохоос сэргийлж, байгаль орчны цогц байдлыг хангах, ил тод, нарийвчлал сайтай, тооцох боломжтой, иж бүрэн, харьцуулах боломжтой байх хэлбэрээр тооцно.
14. Талууд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хүрээнд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болон шингээлтийн талаар арга хэмжээ авах шаардлагатай болохыг ухамсарлаж,



түүнийг хэрэгжүүлэхдээ энэ зүйлийн 13 дахь хэсэгт заасныг баримтлан Конвенцийн хүрээнд гарсан удирдамж, арга зүйг зохих ёсоор харгалзан үзнэ.

15. Талууд Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахдаа, ялангуяа хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх явцад гарч болох үр нөлөөнд эдийн засаг нь эмзэг өртөж болох орнууд, тэр дундаа хөгжиж буй орнуудын нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
16. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хамтран ажиллахаар хэлэлцэн тохирсон Талууд, мөн бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, түүний гишүүн улс нь өөрийн үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг мэдээлэхдээ хэлэлцээрийн нөхцөл, Талуудад хуваарилагдсан тодорхой хугацаанд бууруулах ялгарлын хэмжээ зэргийг Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Нарийн бичгийн дарга нарын газар энэхүү хэлэлцээрийн нөхцлийг оролцогч Талууд болон Конвенцид гарын үсэг зурсан Талуудад мэдээлнэ.
17. Тус хэлэлцээрийн Талууд нь 13 болон 15 дугаар зүйл, мөн энэ зүйлийн 13 болон 14 дэх хэсэгт нийцүүлэн гаргасан дээрх 16 дахь хэсэгт туссан өөрт хуваарилагдсан хүлэмжийн хийн ялгарлын хэмжээнд хариуцлага хүлээнэ.
18. Хэрэв Талууд дээр дурдсан ажлын хүрээнд, эсхүл энэхүү Хэлэлцээрийн оролцогч Тал болох бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллаж байгаа тохиолдолд тус байгууллагын гишүүн улс бүр дангаараа, мөн бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 13 болон 15 дугаар зүйл, мөн энэ зүйлийн 13 болон 14 дэх хэсэгтэй нийцүүлэн гаргасан 16 дахь хэсэгт туссан өөрт хуваарилагдсан хүлэмжийн хийн ялгарлын хэмжээнд хариуцлага хүлээнэ.
19. Бүх Талууд 2 дугаар зүйлийг бүрэн хүлээн зөвшөөрч, өөрийн орны үндэсний онцлог нөхцөлтэй уялдуулан өөрсдийн хүлээх нийтлэг боловч ялгавартай үүрэг хариуцлагад нийцүүлэн, хүлэмжийн хийн ялгарал багатай урт хугацааны хөгжлийн стратеги боловсруулж, мэдээлэхийг эрмэлзэнэ.

5 дугаар зүйл

1. Талууд Конвенцийн 4 дүгээр зүйлийн 1(d) дэх хэсгийн дагуу ой болон хүлэмжийн хийг шингээгч, хураагуурыг зохих ёсоор хамгаалах, сайжруулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.



2. Талууд үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Конвенциор баталсан удирдамж, шийдвэрийн дагуу үр дүнд суурилсан төлбөр тооцоонд үндэслэн хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ. Эдгээр үйл ажиллагаа нь: Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ойг хамгаалах ач холбогдол, ойн тогтвортой менежмент, ойн нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжсэн бодлогын удирдамж, бодит урамшууллаар дамжуулан хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн ойн цогц болон тогтвортой менежментийн хүрээнд ялгарлыг бууруулах, дасан зохицох хамтарсан арга зам зэрэг бодлогын хувилбарт арга замыг дэмжихдээ тэдгээртэй холбоотой урамшууллын ач холбогдол, нүүрстөрөгчийн бус үр ашгийг нь нотлох зэрэг болно.

6 дугаар зүйл

1. Зарим Талууд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэхдээ тогтвортой хөгжлийг дэмжих, байгаль орчны цогц байдлыг хангах, түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагаандaa томоохон зорилт дэвшиүүлэх боломжийг бий болгох зорилгоор сайн дурын үндсэн дээр хамтран ажиллах сонголт хийж болохыг Талууд хүлээн зөвшөөрнө.
2. Талууд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангахын тулд олон улсад дамжуулсан ялгарлыг бууруулах арга хэмжээний үр дүнд түшиглэн, сайн дурын үндсэн дээр хамтарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ тогтвортой хөгжил, байгаль орчны цогц байдлыг хангах, ил тод байдал болон засаглалыг дэмжинэ. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны үүрэг гүйцэтгэх Талуудын Бага хурлаар баталсан удирдамжийн дагуу давхардуулан тооцолохоос зайлсхийж, чадварлаг тооцоо, бүртгэлийн тогтолцоог ашиглана.
3. Хэлэлцээрт тусгагдсан үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангахын тулд олон улсад дамжуулсан ялгарлыг бууруулах арга хэмжээний үр дүнг сайн дурын үндсэн дээр хэрэглэж болох бөгөөд үүнийг оролцогч Талууд баталгаажуулна.
4. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн механизм нь Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын дор байгуулагдсан эрх бүхий байгууллага болон холбогдох зохицуулалтын дагуу бий болох бөгөөд Талууд сайн дурын үндсэн дээр хэрэглэнэ. Энэхүү механизм нь Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны үүргийг гүйцэтгэх Талуудын



Бага хурлаар томилогдсон эрх бүхий байгууллага хяналт дор хэрэглэнэ. Энэ механизмын зорилго нь:

- a. Тогтвортой хөгжлийг дэмжихийн зэрэгцээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хөхиүлэн дэмжих;
 - b. Оролцогч Талын баталгаажуулснаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахдаа олон нийтийн болон хувийн хэвшлийн оролцоог хангах, тэднийг урамшуулах;
 - c. Бусад Талуудын үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо хангахын тул ашиглах боломжтой, ялгарлыг бууруулах үйл ажиллагааны үр дүнг хүртэгч хүлээн авагч Талын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээний бууралтад хувь нэмэр оруулах;
 - d. Дэлхий нийтийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зэрэг болно.
5. Хэрэв бусад Тал өөрийн үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр хэрэгжсэнээр энэ зүйлийн 4 дэх хэсэгт тодорхойлсон механизмын үр дүнд хүлэмжийн хийн ялгарал буурсныг нотлосон тохиолдолд хүлээн авагч Талын үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн амжилтад нөлөөлсөн гэж авч үзэхгүй.
 6. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурал нь энэ зүйлийн 4 дэх хэсэгт тодорхойлсон механизмын хүрээнд олсон үйл ажиллагааны орлогын ноогох хэсгийг захиргааны зардал болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд эмзэг өртөмтгийн хөгжиж буй орнуудын дасан зохицоход шаардлагатай зардалд зарцуулна.
 7. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын анхны хуралдаанаар энэ зүйлийн 4 дэх хэсэгт тодорхойлсон үйл ажиллагааны механизмын дүрэм, нөхцөл, зохион байгуулалтын үйл ажиллагаа зэргийг батална.
 8. Тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг арилгах зорилгод хүрэхийн тулд харилцан уялдаатай, үр дүнтэй арга замаар, үүний дотор ялгарлыг бууруулах, дасан зохицох, санхүүжүүлэх, технологи дамжуулах, чадавх бэхжүүлэх зэрэг аль тохиромжтой аргаар Талуудын үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтэд дэмжлэг болохуйц, нэгдмэл, цогц, тэнцвэртэй зах зээлийн бус арга механизмын чухлыг хүлээн зөвшөөрнө. Эдгээр нь дараах зорилготой. Үүнд:



- а. Ялгарлыг бууруулах, дасан зохицоход чиглэсэн зорилгыг дэмжих;
- б. Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэхэд олон нийтийн болон хувийн секторын оролцоог нэмэгдүүлэх;
- с. Холбогдох зохион байгуулалтын хэлбэр, арга хэрэгслийн хоорондын уялдаа холбоог бий болгох зэрэг болно.
9. Тогтвортой хөгжилд хүрэх зах зээлийн бус арга механизмын тогтолцоо нь энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан зах зээлийн бус арга замыг дэмжих зорилгоор тодорхойлогдоно.

7 дугаар зүйл

- Талууд тогтвортой хөгжлийг дэмжих болон 2 дугаар зүйлд тодорхойлсон агаарын төмөрлөгийн бууруулахад чиглэсэн зорилтуудад нийцүүлэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг дээшлүүлэх, эмзэг өртөмтгий байдлыг бууруулах, даван туулах чадварыг бэхжүүлэх дэлхий нийтийн зорилгыг бий болгоно.
- Дасан зохицох асуудал нь орон нутгийн, үндэсний, бус нутгийн болон олон улсын хэмжээнд тулгарч буй дэлхий нийтийн тулгамдсан асуудал болохыг Талууд хүлээн зөвшөөрч, энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаварт эмзэг өртөмтгий хөгжиж буй орнуудын хэрэгцээ шаардлагыг харгалzan үзсэний үндсэн дээр уур амьсгалын өөрчлөлтөөс ард иргэд, тэдгээрийн амьжиргаа, экосистемийг хамгаалах дэлхий нийтийн урт хугацааны хариу арга хэмжээг дэмжиж буй гол бүрэлдэхүүн хэсэг болохыг хүлээн зөвшөөрнө.
- Хөгжиж буй орнуудын дасан зохицоход чиглэсэн хүчин чармайлт нь Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын анхны хуралдаанаар батлагдах нөхцлийн дагуу хүлээн зөвшөөрөгднө.
- Ялгарлыг өндөр түвшинд бууруулснаар дасан зохицох хүчин чармайлтын нэмэлт хэрэгцээ буурах, мөн дасан зохицох хэрэгцээ өссөнөөр холбогдох зардал өсөх тул Талууд дасан зохицох хэрэгцээ нь маш чухал гэдгийг хүлээн зөвшөөрнө.
- Дасан зохицоход чиглэсэн арга хэмжээг нийгэм-эдийн засаг, байгаль орчны аль шаардлагатай бодлого, арга хэмжээтэй уялдуулах зорилгоор Талууд уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өртөмтгий бүлэг, орон нутгийн иргэд болон



экосистемийн асуудлыг харгалзан үзэж, жөндөрт суурилсан, оролцоог хангасан, ил тод, ойлгомжтой, шинжлэх ухааны шилдэг ололтод тулгуурласан арга хэмжээ авах бөгөөд энэ нь уламжлалт болон нутгийн угуул иргэдийн мэдлэг, орон нутгийн мэдлэгийн системийн аль тохиromжтойд тулгуурласан байхыг Талууд хүлээн зөвшөөрнө.

6. Талууд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд эмзэг өртөмтгий хөгжиж буй орнуудын хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж олон улсын хамтын ажиллагааны хүрээнд дасан зохицох хүчин чармайлтыг дэмжихийн ач холбогдлийг хүлээн зөвшөөрнө.
7. Талууд Канкуны дасан зохицох үндсэн зарчмыг удирдлага болгон дасан зохицоход чиглэсэн арга хэмжээг сайжруулах талаар хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай бөгөөд эдгээр нь:
 - a. Дасан зохицох арга хэмжээний шинжлэх ухаан, төлөвлөлт, бодлого болон хэрэгжилтийн аль тохиromжтойд суурилсан холбогдох мэдээлэл, сайн туршлага, сургамжийн талаар харилцан мэдээлэл солилцох;
 - b. Холбогдох мэдээлэл, мэдлэгийг нийцүүлэх, Талуудад техникийн дэмжлэг болон удирдлагаар хангах тухай Конвенци болон түүний хүрээнд хэрэгжүүлэх энэхүү Хэлэлцээрийн дагуу зохион байгуулалтын хэлбэр бүтцийг бэхжүүлэх;
 - c. Уур амьсгалын талаарх мэдээллийн суурийг бий болгох, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх үүднээс уур амьсгалын талаарх шинжлэх ухааны мэдлэг, түүний дотор цэгцтэй ажиглалт болон эрт сээрэмжлүүлэх системийг бэхжүүлэх;
 - d. Сайн туршлагыг хөхиүлэн дэмжих зорилгоор хөгжиж буй орон болох Талуудад дасан зохицоход чиглэсэн үр дүнтэй туршлага, дасан зохицох хэрэгцээ шаардлага, тэргүүлэх зорилтууд, дасан зохицох чиглэлээр хүлээн авсан дэмжлэг, хүндрэл бэрхшээл, зөрүүтэй байдал зэргийг тодорхойлоход туслалцаа үзүүлэх,
 - e. Дасан зохицох арга хэмжээний үргэлжлэх хугацаа, үр дүнг нэмэгдүүлэх зэрэг болно.
8. Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагууд нь энэ зүйлийн 7 дахь хэсэгт тодорхойлсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн Талуудын хүчин чармайлтыг энэ зүйлийн 5 дахь хэсгийг удирдлага болгон дэмжинэ.



9. Талууд тус бүр дасан зохицоход чиглэсэн төлөвлөлт, арга хэмжээг хэрэгжүүлэх, ялангуяа холбогдох төлөвлөгөө, бодлого, хувь нэмрийг боловсруулах болон сайжруулах аль тохиромжтой үйл явцад оролцох бөгөөд эдгээр нь:
- Дасан зохицоход чиглэсэн арга хэмжээ, оролдлого, хүчин чармайлтыг хэрэгжүүлэх;
 - Дасан зохицоход чиглэсэн үндэсний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц;
 - Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өртөмтгий хүн ам, газар нутаг болон экосистемийг харгалzan үзсэний үндсэн дээр үндэсний хэмжээнд тодорхойлсон тэргүүлэх арга хэмжээг боловсруулах зорилгоор уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, эмзэг өртөмтгий байдлыг үнэлэх;
 - Дасан зохицоход чиглэсэн төлөвлөгөө, бодлого, хөтөлбөр, арга хэмжээнээс суралцах, түүнийг хянах, үнэлэх; болон,
 - Нийгэм-эдийн засгийн тогтолцоо, экосистемийн даван туулах чадвар, үүний дотор эдийн засгийн төрөлжилт болон байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг бий болгох.
10. Талууд тус бүр дасан зохицоход чиглэсэн арга хэмжээний тэргүүлэх чиглэл, хэрэгжилт болон дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага, төлөвлөгөө болон арга хэмжээг агуулсан мэдээллийг хөгжиж буй орон болох Талуудад нэмэлт ачаалал үүсгэхгүйгээр тогтмол хугацаанд хүргүүлэх бөгөөд шаардлагатай үед шинэчилнэ.
11. Энэ зүйлийн 10 дахь хэсэгт тодорхойлсон дасан зохицох арга хэмжээний мэдээллийг бусад мэдээлэл, баримт бичиг болох 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан дасан зохицоход чиглэсэн үндэсний төлөвлөгөө, үндэсний хэмжээнд тодорхойлогдсон хувь нэмэр болон үндэсний мэдээлэл зэрэгтэй уялдуулан тогтмол хугацаанд шинэчилж, хүргүүлнэ.
12. Энэ зүйлийн 10 дахь хэсэгт тодорхойлсон дасан зохицоход чиглэсэн арга хэмжээний мэдээлэл нь Нарийн бичгийн дарга нарын газрын олон нийтийн бүртгэлд бүртгэгдэнэ.



13. Хөгжиж буй орон болох Талуудад энэ зүйлийн 7,9,10 болон 11 дэх хэсгийг хэрэгжүүлэхэд нь Хэлэлцээрийн 9,10 болон 11 дүгээр зүйлийг үндэслэн олон улсын дэмжлэгийг үргэлжлүүлэн, ахисан түвшинд үзүүлнэ.

14. 14 дүгээр зүйлд тодорхойлсон дэлхий нийтийн төлөв байдал нь дараах зорилготой. Тухайлбал:

a. Хөгжиж буй орнуудын дасан зохицоход чиглэсэн хүчин чармайлтыг дэмжих;

b. Энэ зүйлийн 10 дахь хэсэгт тодорхойлсон дасан зохицоход чиглэсэн мэдээллийг үндэслэн дасан зохицох арга хэмжээний хэрэгжилтийг идэвхижүүлэх;

c. Дасан зохицох чиглэлээр үзүүлсэн дэмжлэг, түүний үр дүн, оновчтой байдлыг үнэлэх; болон

d. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон дэлхий нийтийн дасан зохицох зорилгод хүрэхийн тулд гарсан ахиц, дэвшлийг үнэлэх.

8 дугаар зүйл

1. Талууд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар болох цаг агаарын аюултай үзэгдэл болон алгуур бүрэлдэх үзэгдэл зэргээс үүдэн гарах алдагдал, хохирлыг баагах, түүнийг арилгах, урьдчилан сэргийлэх, түүнчлэн алдагдал, хохирлын эрсдлийг бууруулахад тогтвортой хөгжлийн оруулах хувь нэмрийг хүлээн зөвшөөрнө.
2. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах алдагдал, хохирлыг барагдуулах Варшавын олон улсын механизм нь Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэгч Талуудын Бага хурлын чиглэл, удирдлага дор хэрэглэгдэх бөгөөд Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэгч Талуудын Бага хурлаас тогтоосны дагуу түүнийг өргөжүүлж, бэхжүүлж болно.
3. Талууд Уур амьсгалын өөрчлөлтөөс учрах алдагдал, хохирлын талаарх ойлголт, арга хэмжээ болон дэмжлэгийг Варшавын олон улсын механизмыг ашиглан, хамтарсан болон хөнгөвчилсөн арга замын аль тохиромжтойгоор сайжруулна.
4. Дээр дурдсан ойлголт, арга хэмжээ, дэмжлэгийг сайжруулах, хамтарсан болон хөнгөвчилсөн арга зам нь:



- a. Эртнээс сэрэмжлүүлэх систем;
 - b. Онцгой байдлын бэлэн байдал;
 - c. Алгуур бүрэлдэх гамшигт үзэгдэл;
 - d. Нөхөгдөшгүй болон байнгын гарз, хохирол учруулж болох гамшигт үзэгдэл;
 - e. Эрсдлийн цогц үнэлгээ болон удирдлага;
 - f. Эрсдэлийн даатгалын арга хэрэгсэл, уур амьсгалын эрсдэлийн сан болон бусад даатгалын шийдлүүд;
 - g. Эдийн засгийн бус алдагдал;
 - h. Хүн ам, тэдгээрийн амжиргаа, экосистемийн даван туулах чадвар.
5. Варшавын олон улсын механизм нь Хэлэлцээрийн дагуу бий болсон байгууллага болон шинжээчид, мөн Хэлэлцээрээс гадуурх холбогдох байгууллага болон шинжээчидтэй хамтран ажиллана.

9 дүгээр зүйл

1. Хөгжингүй орон болох Талууд нь хөгжиж буй орон болох Талуудад ялгарлыг бууруулах болон дасан зохицоход чиглэсэн Конвенциор хүлээсэн үүрэг, хариуцлагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор санхүүгийн эх үүсвэрээр хангана.
2. Бусад Талууд энэ төрлийн дэмжлэгийг сайн дурын үндсэн үргэлжлүүлэн үзүүлж болно.
3. Дэлхий нийтийн хүчин чармайлтын нэг хэсэг хөгжингүй орон болох Талууд нь уур амьсгалын санхүүжилтийг олон төрлийн эх үүсвэр, арга хэрэгсэл болон бусад сувгаас бий болгоход, түүнчлэн тухайн улсад тохирсон стратеги, хөгжиж буй орон болох Талуудын хэрэгцээ шаардлага, тэргүүлэх чиглэлийг харгалzan үзэж олон төрлийн арга хэмжээг авсанаар төрийн санхүүгийн эх үүсвэрийн чухал ач холбогдлыг тэмдэглэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Ийнхүү уур амьсгалын санхүүжилтийг бий болгохдоо өмнөх хүчин чармайлтаас илүү ахиц дэвшил үзүүлэх ёстой.



4. Санхүүжилтийн эх үүсвэрийн талаарх зүйл заалт нь хөгжиж буй орон болох Талуудын, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өртөмтгий болон чадавхын хувьд хязгаарлагдмал улс орнууд, хөгжиж буй жижиг арлын улсын хэрэгцээ шаардлага, тухайн оронд тохирсон стратеги, тэргүүлэх зорилтуудыг харгалзан үзсэний үндсэн дээр ялгарлыг бууруулах, дасан зохицох арга хэмжээний тэнцвэрт байдлыг хангахад орших бөгөөд энэ нь дасан зохицоход чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэрийн хэрэгцээг харгалзана.
5. Хөгжингүй орон болох Талууд нь энэ зүйлийн 1 болон 3 дахь хэсэгт заасны дагуу тооцсон тоон болон чанарын мэдээллийг, хөгжиж буй орны Талуудад олгох төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөсөн хэмжээний мэдээллийн хамт 2 жил тутамд гаргаж мэдээлнэ.
6. 14 дүгээр зүйлд тодорхойлсон Дэлхий нийтийн төлөв байдал нь хөгжингүй орон болох Талуудаас, эсхүл Хэлэлцээрийн дор байгуулагдсан байгууллагаас уур амьсгалын санхүүжилттэй холбоотой хүчин чармайлтын талаар гаргасан мэдээллийг харгалзан үзнэ.
7. 13 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасны дагуу Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын анхны хуралдаанаар баталсан дүрэм, зохион байгуулалтын үйл ажиллагаа, нөхцлийн дагуу хөгжингүй орон болох Талууд Хөгжиж буй орон болох Талуудад үзүүлсэн олон нийтийн оролцоог дайчилсан дэмжлэгийн талаархи ил тод, харилцан уялдаатай мэдээллийг 2 жил тутамд мэдээлнэ. Бусад Талууд мөн мэдээлж болно.
8. Конвенцийн санхүүгийн механизм, түүнийг удирдах үүрэг бүхий байгууллага нь энэхүү Хэлэлцээрийн санхүүгийн механизмын үүрэг гүйцэтгэнэ.
9. Хэлэлцээрт үүрэг гүйцэтгэгч байгууллагууд, үүний дотор Конвенцийн Санхүүгийн механизмыг удирдах үүрэг бүхий байгууллага нь хөгжиж буй орон болох Талуудад, ялангуяа хөгжиж буй арлын жижиг улсад, тэдгээрийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх үндэсний стратеги, төлөвлөгөөг харгалзан үзсэний үндсэн дээр хялбаршуулсан төлбөрийн баталгаажуулалт, дэмжлэгт сууриссан, үр дүнтэй санхүүжилтийн эх үүсвэрийн хуртээмжийг нэмэгдүүлэхийг зорино.

10 дугаар зүйл

1. Талууд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадварыг дээшлүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор технологийн хөгжил болон



технологи дамжуулалтын ач холбогдол бүхий урт хугацааны төсөөллийн талаар харилцан мэдээлнэ.

2. Талууд Хэлэлцээрийн дагуу ялгарлыг бууруулах болон дасан зохицоход чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ технологийн ач холбогдлыг тэмдэглэн, технологийг байршуулах болон түгээх хүчин чармайлтыг хүлээн зөвшөөрч, технологи хөгжүүлэх, дамжуулахад чиглэсэн хамтарсан үйл ажиллагааг бэхжүүлнэ.
3. Конвенцийн дагуу байгуулагдсан технологийн механизмын нь энэхүү Хэлэлцээрийн үүрэг гүйцэтгэнэ.
4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон урт хугацааны төсөөлөл хүрэхийн тулд Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, технологи хөгжүүлэлт, дамжуулалтын арга хэмжээг хөнгөвчлөх, дэмжихэд технологийн механизмын ажлыг чиглүүлэх зорилготой технологийн тогтолцоо нь үүгээр байгуулагдана.
5. Инновацийг бий болгох, дэмжих, хурдасгах нь тогтвортой хөгжлийг хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үр дүнтэй, урт хугацааны хариу арга хэмжээ авахад нэн чухал. Энэхүү хүчин чармайлтыг санхүүгийн арга хэрэгслээр технологийн механизм болон Конвенцийн санхүүгийн механизмын аль тохирх арга замаар дэмжих бөгөөд судалгаа, хөгжүүлэлтийн хамтарсан удирдамжийн дагуу технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар технологийн мөчлөгийн бүх үе шатанд хөгжиж буй орон болох Талуудыг дэмжинэ.
6. Ялгарлыг бууруулах, дасан зохицоход чиглэсэн дэмжлэгийн хоорондын тэнцвэрт байдлыг хангахын тулд энэ зүйлийн хэрэгжилтийг хангах, ялангуяа технологийн хөгжил, дамжуулалтыг технологийн үе шат болгонд дэмжих, хамтын ажиллагаанд үндэслэсэн арга хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хөгжиж буй орон болох Талуудад санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлнэ. 14 дүгээр зүйлд заасан дэлхий нийтийн төлөв байдал нь хөгжиж буй орон болох Талуудын технологийн хөгжил, технологи дамжуулалтыг дэмжих хүчин чармайлттай холбоотой мэдээллийг харгалзан авч үзнэ.

11 дүгээр зүйл

1. Хэлэлцээрт тодорхойлсон чадавх бэхжүүлэх арга хэмжээ нь хөгжиж буй орон болох Талууд, үүний дотор уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаварт эмзэг өртөмтгий, нэн буурай хөгжилтэй орон, хөгжиж буй арлын жижиг улсын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг чиглэсэн үр дүнтэй арга



хэмжээ, тухайлбал, дасан зохицох болон ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэхэд оршино. Энэ нь технологийн хөгжил, суурилуулалт болон түгээлт, уур амьсгалын санхүүжилтийн хүртээмж, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, боловсон хүчин бэлтгэх, олон нийтийг мэдээллээр хангах болон мэдээллийг ил тодор, цаг хугацаанд нь, үнэн зөв мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2. Чадавх бэхжүүлэх нь тухайн улсад тохирсон, үндэсний хэрэгцээнд тулгуурласан, Талуудын, ялангуяа хөгжиж буй орон болох Талуудын эзэмшлийг үндэсний болон орон нутгийн түвшинд дэмжсэн байна. Чадавх бэхжүүлэх нь Конвенцийн чадавх бэхжүүлэх арга хэмжээний үр дүнд гарсан сургамжид тулгуурлах бөгөөд энэ нь үр дүнтэй, өргөн оролцоог хангасан, давтамжит үйл явц байх бөгөөд нийтлэг шинжтэй, жендерийн асуудлыг харгалзан үзнэ.
3. Бүх Талууд Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахын тулд хөгжиж буй орон болох Талуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор хамтран ажиллана. Хөгжингүй орон болох Талууд нь хөгжиж буй орон болох Талуудын чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнд үзүүлж буй дэмжлэгийг өргөжүүлэн сайжруулна.
4. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх хөгжиж буй орон болох Талуудын чадавхыг бус нутгийн, хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд бэхжүүлэхээр зорьж буй Талууд нь чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний талаар тогтмол мэдээлнэ. Хөгжиж буй орон болох Талууд чадавх бэхжүүлэх төлөвлөгөө, бодлого, үйл ажиллагаа, арга хэмжээ, хэрэгжүүлэх явцад гарч буй ахиц, дэвшлийг тогтмол мэдээлнэ.
5. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа нь Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн болон Конвенцийн хүрээнд бий болсон тогтолцооны хүрээнд сайжирна. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын анхны хуралдаанаар чадавх бэхжүүлэх анхан шатны бүтэц зохион байгуулалтын шийдвэрийг батална.

12 дугаар зүйл

Хэлэлцээрийн дагуу уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх, боловсон хүчин бэлтгэх, олон нийтийг мэдээллээр хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн хүртээмжтэй байдлыг сайжруулах зэрэг чиглэлээр Талууд хамтран ажиллана.



13 дугаар зүйл

1. Талуудын чадавхын ялгаатай байдлыг харгалзсан, хуримтлагдсан туршлагад суурилсан уян хатан үйл ажиллагаа, дэмжлэгийг сайжруулах зорилготой харилцан итгэлцлийг бий болгох, үр дүнтэй хэрэгжилтийг дэмжих ил тод байдлын тогтолцоо үүгээр байгуулагдана.
2. Ил тод байдлын тогтолцоо нь хөгжиж буй орны Талуудад энэ зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн уян хатан нөхцлийг тэдгээрийн чадавхыг харгалзан олгоно. Энэ зүйлийн 13 дугаар хэсэгт тодорхойлсон журам, заавар, нөхцөл нь энэхүү уян хатан байдлыг илэрхийлнэ.
3. Ил тод байдлын тогтолцоо нь буурай хөгжилтэй орнууд болон хөгжиж буй арлын жижиг улсын онцлог байдлыг хүлээн зөвшөөрснөөр Конвенцийн хүрээнд ил тод байдлын зохицуулалтыг бий болгож, түүнийг сайжруулах бөгөөд энэ нь хөнгөвчилсөн, халдашгүй, шийтгэл оногдуулахгүй байх хэлбэрээр үндэсний тусгаар тогтолыг дээдэлж, Талуудад хэт ачаалал өгөхөөс зайлсхийх замаар хэрэгжинэ.
4. Үндэсний мэдээлэл, хоёр жил тутмын тайлан болон хоёр жил тутмын шинэчилсэн тайлан, олон улсын үнэлгээ, зөвлөгөө болон судалгаа зэргийг багтаасан Конвенцийн хүрээнд бий болж буй ил тод байдлын зохицуулалт нь энэ зүйлийн 13 дахь хэсэгт заасан нөхцөл, журам зааврыг боловсруулахад бий болсон туршлагын зарим хэсгийг бүрдүүлнэ.
5. Энэхүү ил тод байдлын тогтолцооны зорилго нь Конвенцийн 2 дугаар зүйлд заасан зорилгын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тодорхой ойлголт бий болгох, түүний дотор 4 дүгээр зүйлд заасан үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэрийн тодорхой байдал, үйл явцыг үнэлэх, 7 дугаар зүйлд заасан Талуудын дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагаа, түүнчлэн сайн туршлага, тэргүүлэх зорилтууд, хэрэгцээ шаардлага болон дутагдал зэргийг харгалзан, 14 дүгээр зүйлд заасан дэлхий нийтийн төлөв байдлын үр дүнгийн мэдээллийн суурийг бий болгоход оршино.
6. Энэхүү ил тод байдлын тогтолцооны зорилго нь 4,7,9,10 болон 11 дүгээр зүйлд заасан уур амьсгалын өөрчлөлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд Талуудын үзүүлсэн болон хүлээн авсан дэмжлэг, түүнчлэн 14 дүгээр зүйлд заасан дэлхий нийтийн төлөв байдлын үр дүнд мэдээллийн суурийг бий болгоход зориулагдсан санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тоймлон гаргахад оршино.



7. Талууд дараах мэдээллийг тогтмол гаргаж өгнө. Үүнд:
- Парисын Хэлэлцээрт оролцогч Талын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаар дэмжигдсэн Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын шинжээчдийн зөвлөлөөс батлан гаргасан сайн туршлага бүхий арга зүйг ашиглан бэлтгэсэн хүний үйл ажиллагааны улмаас үүссэн хүлэмжийн хийн хаягдлын ялгарах хэмжээ болон шингээгчээс нэвчих хэмжээний үндэсний тооллогын тайлан;
 - b. 4 дүгээр зүйлд заасан үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэрт хүрэх, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ахиц, дэвшлийг үнэлэхэд шаардагдах мэдээлэл.
8. Талууд 7 дугаар зүйлд заасан уур амьсгалын өөрчлөлт болон дасан зохицоход чиглэсэн шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.
9. Хөгжингүй орон болох Талууд, дэмжлэг үзүүлэх бусад Талууд нь 9,10 болон 11 дүгээр зүйлд заасны дагуу Хөгжиж буй орон болох Талуудад үзүүлсэн санхүүжилт, технологи дамжуулалт, чадавх бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийн талаарх мэдээллийг гаргаж өгнө.
- 10.Хөгжиж буй орны Талууд нь 9,10 болон 11 дүгээр зүйлд заасны дагуу шаардагдсан болон хүлээн авсан санхүүжилт, технологи дамжуулалт, чадавх бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийн талаарх мэдээллийг гаргаж өгнө.
- 11.Энэ зүйлийн 7 болон 9 дүгээр хэсгийн дагуу гаргасан Талуудын мэдээллийг 1/CP.21 шийдвэрийн дагуу шинжээчдийн баг хянан хэлэлцэнэ. Хяналтын үйл ажиллагаа нь чадавх бэхжүүлэх шаардлагатай хөгжиж буй орнуудын чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход туслалцаа үзүүлнэ. Түүнчлэн, Талууд 9 дүгээр зүйлд заасан хүчин чармайлт, үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилт, бүх талын дэмжлэгтэйгээр, олон талт хамтын ажиллагааны арга замаар оролцно.
- 12.Шинжээчдийн хянан хэлэлцэх ажиллагаа нь Талуудын үзүүлсэн дэмжлэг, үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилт, ололт амжилт зэргийг анхаарч авч үзнэ. Хянан хэлэлцэх ажиллагаа нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан уян хатан нөхцлийг харгалзан үзэж, хүргүүлсэн мэдээлэл нь энэ зүйлийн 13 дахь хэсэгт тодорхойлсон нөхцөл, журам заавартай нийцэж байгаа эсэх болон Талуудын сайжруулах шаардлагатай ажлын хүрээг тодорхойлно. Хянан хэлэлцэх ажиллагаа нь хөгжиж буй орон болох Талуудын онцлог нөхцөл, үндэсний чадавхид онцгой анхаарал хандуулна.



13. Парисын Хэлэлцээрийн оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын анхны хуралдаанаар Конвенциор бий болсон ил тод байдлын тогтолцооны туршлагыг хуримтлуулах, энэ зүйлийн заалтуудыг боловсруулах, үйл ажиллагааны болон дэмжлэгийн ил тод байдалд чиглэсэн нийтлэг нөхцөл, журам, удирдамж зэргийг батална.

14. Хөгжиж буй орон болох Талуудад энэ зүйлийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

15. Хөгжиж буй орон болох Талуудад ил тод байдалтай холбоотой чадавх бэхжүүлэх дэмжлэгийг тогтмол үзүүлнэ.

14 дүгээр зүйл

1. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурал нь урт хугацааны зорилго болон Хэлэлцээрийн зорилгыг хангахад үзүүлсэн нийт ахиц дэвшлийг үнэлэх зорилгоор Хэлэлцээрийн хэрэгжилтийн төлөв байдлыг тогтмол хугацаанд хүлээн авна. (Цаашид “дэлхий нийтийн төлөв байдал” гэх) Үүнийг шудрага байдал болон шинжлэх ухааны ололт амжилтад нийцүүлэн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох арга замыг харгалзан үзэж иж бүрнээр, бүх талын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
2. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурал нь анхны дэлхий нийтийн төлөв байдлыг 2023 онд гаргах бөгөөд Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол түүний дараагаас 5 жил тутамд гаргана.
3. Дэлхий нийтийн төлөв байдлаас гарсан үр дүн нь Талуудад тэдгээрийн авч хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон арга хэмжээ, дэмжлэгийг энэхүү Хэлэлцээрийн холбогдох зүйл заалтын дагуу шинэчлэх, сайжруулах, түүнчлэн уур амьсгалын талаар авч хэрэгжүүлэх олон улсын хамтын ажиллагааг сайжруулах суурь мэдээлэл болно.

15 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн зүйл заалтын дагуу үйл ажиллагааны хэрэгжилтийг хөнгөвчлөх, дэмжих механизм үүгээр байгуулагдана.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон механизмыг нь ил тод, зөрчилгүй, шийтгэл оногдуулах зорилгогүй, шинжээчийн мэдлэгт тулгуурласан дэмжигч



хороо байна. Энэхүү хороо нь Талуудын онцлог нөхцөл, үндэсний чадавхид анхаарал хандуулна.

3. Энэхүү хороо нь Парисын хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын анхны хуралдаанаас баталсан нөхцөл болон зохицуулалтын дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд ажлаа Парисын хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хуралд жил тутам тайлагнана.

16 дугаар зүйл

1. Конвенцийн дээд байгууллага болох Талуудын Бага хурал нь энэхүү Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны үүрэг гүйцэтгэнэ.
2. Энэхүү Хэлэлцээрт оролцогч Тал болоогүй боловч Конвенцид оролцогч Талууд нь энэхүү Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын аль ч хуралдаанд ажиглагчаар оролцож болно. Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаар гаргах холбогдох шийдвэрийг зөвхөн энэхүү Хэлэлцээрт оролцогч Талууд гаргана.
3. Талуудын Бага хурал нь энэхүү Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны үүргийг гүйцэтгэж байх үед Талуудын Бага хурлын товчооны аль нэг гишүүн Конвенцийн Талыг төлөөлж байгаа боловч тухайн Тал энэхүү Хэлэлцээрт оролцогч Тал болоогүй байгаа бол түүнийг Хэлэлцээрт оролцогч Талуудаас сонгогдсон нэмэлт гишүүн орлоно.
4. Энэхүү Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурал Хэлэлцээрийн хэрэгжилтийн тухай мэдээллийг тогтмол авч, хянах болон өөрийн бүрэн эрхийн хүрээнд түүний үр дүнтэй хэрэгжихэд дэмжлэг үзүүлэх шийдвэрүүдийг гаргана. Бага хурал энэхүү Хэлэлцээрээр түүнд оногдуулсан дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - а. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх туслах чиг үүргийн байгууллагыг байгуулах; болон
 - б. Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай өөр бусад үйл ажиллагааг явуулах.
5. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаар зөвшилцсөнөөс өөр шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд Талуудын Бага хурлын үйл ажиллагааны дүрэм болон



Конвенцийн дагуу хэрэглэгдэх санхүүгийн ажиллагаа нь энэхүү Хэлэлцээрт mutatis mutandis-aap хэрэглэгдэнэ.

6. Нарийн бичгийн дарга нарын газар Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын анхны хуралдааныг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа хуралдуулахаар төлөвлөсөн Талуудын Бага хурлын анхны хуралдаантай хамт зарлан хуралдуулна. Энэхүү Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын дараа дараагийн ээлжит хуралдааныг энэхүү Хэлэлцээрийн Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурал өөрөөр шийдвэр гаргаагүй бол Талуудын Бага хурлын ээлжит хуралдаантай хамт жил бүр хуралдуулна.
7. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын ээлжит бус хуралдааныг энэхүү Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурал шаардлагатай гэж үзсэн, эсхүл аль нэг Талаас бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Нарийн бичгийн дарга нарын газраас энэ хүсэлтийг Талуудад мэдээлснээс хойш 6 сарын дотор энэ шаардлага нь оролцогч Талуудын гуравны нэгээс доошгүй тооны дэмжлэг авсан тохиолдолд зарлан хуралдуулна.
8. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын цөмийн эрчим хүчний агентлаг, мөн Конвенцийн Тал биш эдгээр байгууллагын гишүүн болон ажиглагч аль ч орон энэхүү Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хуралд ажиглагчаар оролцож болно. Нарийн бичгийн дарга нарын газарт Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын хуралдаанд ажиглагчаар оролцох хүсэлтээ гаргасан энэхүү Хэлэлцээрийн үйл ажиллагааны хүрээнд хамаарах асуудлаар зохих эрх бүхий үндэсний болон олон улсын, төрийн болон төрийн бус аль ч алба, байгууллагыг оролцогч Талуудын гуравны нэгээс доошгүй нь эсэргүүцээгүй тохиолдолд хуралдаанд ажиглагчаар оролцуулж болно. Ажиглагчаар оролцохыг зөвшөөрөх болон ажиглагчаар оролцох нь энэ зүйлийн 5 дахь хэсэгт тодорхойлсон үйл ажиллагааны дүрмээр зохицуулагдана.

17 дугаар зүйл

1. Конвенцийн 8 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан Нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү Хэлэлцээрийн Нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэнэ.



- Нарийн бичгийн дарга нарын газрын чиг үүргийн талаарх Конвенцийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг зохион байгуулах тухай Конвенцийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь энэхүү Хэлэлцээрт mutatis mutandis-аар хэрэглэгдэнэ. Мөн түүнчлэн, Нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү Хэлэлцээр болон Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаас хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэнэ.

18 дугаар зүйл

- Конвенцийн 9 болон 10 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан Шинжлэх ухаан, технологийн асуудлаар зөвлөгөө өгөх туслах чиг үүргийн байгууллага болон Хэрэгжилтийн туслах чиг үүргийн байгууллага нь энэхүү Хэлэлцээрийн Шинжлэх ухаан, технологийн асуудлаар зөвлөгөө өгөх туслах чиг үүргийн байгууллага болон Хэрэгжилтийн туслах чиг үүргийн байгууллагын үүрэг гүйцэтгэнэ. Эдгээр хоёр байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Конвенцийн зүйл заалтууд энэхүү Хэлэлцээрт mutatis mutandis-аар хэрэглэгдэнэ. Хэлэлцээрийн Шинжлэх ухаан, технологийн асуудлаар зөвлөгөө өгөх туслах чиг үүргийн байгууллага болон Хэрэгжилтийн туслах чиг үүргийн байгууллагын уулзалтын хуралдаан нь Конвенцийн дор байгуулагдсан Шинжлэх ухаан, технологийн асуудлаар зөвлөгөө өгөх туслах чиг үүргийн байгууллага болон Хэрэгжилтийн туслах чиг үүргийн байгууллага тус бүрийн хуралдаантай хамтран хуралдана.
- Энэхүү Хэлэлцээрийн оролцогч Тал биш ч Конвенцийн оролцогч Тал бол эдгээр туслах чиг үүргийн байгууллагын аль ч хуралдааны үйл ажиллагаанд ажиглагчаар оролцож болно. Туслах чиг үүргийн байгууллага нь энэхүү Хэлэлцээрийн туслах байгууллагын үүрэг гүйцэтгэж байх үед Хэлэлцээрийн хүрээнд гаргах аливаа шийдвэрийг зөвхөн энэхүү Хэлэлцээрт оролцогч Талууд гаргана.
- Конвенцийн 9 болон 10 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан туслах чиг үүргийн байгуулага нь энэхүү Хэлэлцээрт хамарагдах үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэж байх үед Конвенцийн оролцогч Тал боловч энэхүү Хэлэлцээрийн оролцогч Тал бус туслах чиг үүргийн байгууллагын товchoоны гишүүнийг энэхүү Хэлэлцээрт оролцогч Талууд дундаас нэмж орлуулан сонгоно.

19 дүгээр зүйл

- Конвенцийн дагуу болон түүний дор байгуулагдсан, энэхүү Хэлэлцээрт тодорхойлогдсоноос бусад туслах чиг үүргийн байгууллага болон зохион



байгуулалтын тогтолцоо нь Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлын шийдвэрийн дагуу энэхүү Хэлэлцээрийн үүргийг хүлээн гүйцэтгэнэ. Ийм туслах чиг үүргийн байгууллага, эсхүл зохион байгуулалтын чиг үүргийг Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаас тодорхойлно.

2. Парисын Хэлэлцээрт оролцогч Талуудын хуралдааны чиг үүргийг гүйцэтгэх Талуудын Бага хурлаас эдгээр Туслах чиг үүргийн байгууллага болон зохион байгуулалтын тогтолцоонд нэмэлт удирдлагаар хангаж болно.

20 дугаар зүйл

1. Конвенцийн Талууд болох гишүүн улс болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нь энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурах болон соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах нь нээлттэй байна. Нью-Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 2017 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд гарын үсэг зурах нь нээлттэй. Цаашид, Хэлэлцээрт нэгдэн орох нь түүнд гарын үсэг зурахад нээлттэй хугацаа дууссаны дараагийн өдрөөс эхлэн нээлттэй. Хэлэлцээрийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан болон нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг Эх хадгалагчид хадгалуулна.
2. Энэхүү Хэлэлцээрийн оролцогч Тал болсон нэг ч гишүүн орон байхгүй бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны аль нэг байгууллага энэхүү Хэлэлцээрийн оролцогч Тал болоход уг Хэлэлцээрт заасан бүхий л үүргийг биелүүлнэ. Нэг болон түүнээс дээш гишүүн орон нь тус Хэлэлцээрийн оролцогч Тал болсон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хувьд уг байгууллага болон түүний гишүүн орон нь тус Хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд тус тусын хүлээх хариуцлагын талаар шийдвэр гаргана. Ийм тохиолдолд уг байгууллага болон түүний гишүүн орон Хэлэлцээрээс урган гарч буй эрхийг давхардуулан эдлэхгүй.
3. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нь соёрхон батласан, хүлээн зөвшөөрсөн, баталсан болон нэгдэн орсон тухай батламж жуух бичигт тус Хэлэлцээрээр зохицуулагдах асуудлаар өөрийн эдлэх эрхийн хэмжээг мэдэгдэнэ. Эдгээр байгууллага нь өөрийн эдлэх эрхийн хэр хэмжээг өөрчилсөн бол энэ тухай Эх хадгалагчид мэдээлэх бөгөөд Эх хадгалагч нь бусад Талуудад мэдээлнэ.



21 дүгээр зүйл

- Хэлэлцээр нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгарлын 55-аас багагүй хувийг бүрдүүлж буй Конвенцийн 55-аас цөөнгүй оролцогч Тал соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан болон нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 30 дахь хоногт хүчин төгөлдөр болно.
- Энэ зүйлийн 1 дэх хэсэгт туссан “дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгарал” гэдэгт Конвенцийн оролцогч Талууд тус Хэлэлцээрийг байгуулсан өдрөөс өмнө мэдээлсэн хамгийн сүүлийн үеийн ялгарлын хэмжээг ойлгоно.
- Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцлийг хангасны дараа уг Хэлэлцээрийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан болон нэгдэн орсон улс, эсхүл бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаас байгууллагаас Хэлэлцээрийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан болон нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь хоногт Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.
- Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас хадгалуулахаар өгсөн баримт бичиг нь уг байгууллагын гишүүн орны хадгалуулахаар өгсөн баримт бичгийн нэмэлт гэж тооцогдохгүй.

22 дугаар зүйл

Конвенцийн 15 дугаар зүйлд заасан Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай заалтууд энэхүү Хэлэлцээрт mutatis mutandis-aap хэрэглэгдэнэ.

23 дугаар зүйл

- Конвенцийн 16 дугаар зүйлд заасан Конвенцийн хавсралтыг батлах болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай заалтууд энэхүү Хэлэлцээрт mutatis mutandis-aap хэрэглэгдэнэ.
- Хэлэлцээрийн хавсралтууд нь түүний салшгүй хэсэг бөгөөд өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрээс иш татах нь түүний хавсралтаас иш татахтай адилд тооцогдоно. Уг хавсралтууд нь жагсаалт, маягт түүнчлэн шинжлэх ухаан, техник, дүрэм журам, удирдлага зохицуулалтын хэлбэр бүхий тодорхойлж тайлбарласан бусад материалыаас бүрдэх бөгөөд түүнээс хэтрэхгүй байна.



24 дүгээр зүйл

Конвенцийн 14 дүгээр зүйлд заасан маргаан шийдвэрлэх тухай заалтууд энэхүү Хэлэлцээрт mutatis mutandis-aар хэрэглэгдэнэ.

25 дугаар зүйл

1. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд оролцогч Тал тус бүр нэг санал өгөх эрхтэй.
2. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага тэдгээрийн эрх мэдлийн хүрээний асуудлаарх санал хураалтад оролцохдоо уг Хэлэлцээрт оролцогч түүний гишүүн орны тоотой тэнцэх санал өгөх эрх эдэлнэ. Хэрэв уг байгууллагын аль нэг гишүүн орон нь өөрийнхөө санал өгөх эрхийг дангаараа эдлэх юм бол уг байгууллага төлөөлөн санал өгөх эрхгүй бөгөөд мөн байгууллага төлөөлж санал хураалтад оролцсон орон дангаараа санал өгөх эрхгүй.

26 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн Эх хадгалагчийн үүргийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

27 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт ямар нэгэн тайлбар хийж болохгүй.

28 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрт оролцогч Талын хувьд Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос гурван жилийн дараагаас эхлэн хэдийд ч Эх хадгалагчид бичгээр мэдэгдсэнээр Хэлэлцээрээс гарч болно.
2. Хэлэлцээрээс гарах нь Хэлэлцээрээс гарах мэдэгдлийг Эх хадгалагч хүлээн авснаас хойш нэг жилийн дараа, эсхүл Хэлэлцээрээс гарах мэдэгдэлд тусгах боломжтой хожуу хугацаа өнгөрсний дараа хүчинтэй болно.
3. Конвенциос гарч байгаа аливаа Тал энэхүү Хэлэлцээрээс мөн гарч байгаад тооцогдоно.



29 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн эх хувийг англи, араб, испани, орос, хятад болон франц хэлээр адил хүчинтэй үйлдсэн бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

Парис хотноо хоёр мянга арван таван оны арван хоёрдугаар сарын арван хоёрны өдөр үйлдэв.

ДЭЭРХИЙГ НОТОЛЖ дор дурдсан нэр бүхий төлөөлөгчид бүрэн эрхийнхээ дагуу энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

